



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/Ч/Д

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, 4.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Жүдо бөхийн Олон улсын хэмжээний мастер, Дэлхийн 2024 оны аварга, Хөвсгөл аймгийн иргэн Бавуудоржийн Баасанхүү нь “Парис-2024” зуны олимпод жүдо бөхийн төрөлд Монгол улсаа төлөөлөн оролцож олимпын мөнгөн медаль авсанд баяр хүргэж 2 өрөө байраар шагнасугай.

2. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7-р баг 7676-4 байр 5 давхар 35 тоот хаягт байршилтай 48,4 м.кв талбай, 2 өрөө орон сууцны зардалд 125,840,000 (Нэг зуун хорин таван сая найман зуун дөчин мянга) төгрөгийг зарцуулсугай.

3. Дээрх зардлын 125,840,000 (Нэг зуун хорин таван сая найман зуун дөчин мянган) төгрөгийг аймгийн “Засаг даргын Тамгын газрын биеийн тамирын спорт дэмжих хөтөлбөрийн нийтийн биеийн тамирын зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712011241